



БАЯНХОНГОР АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/АА

Эмээлтолгой

Г

Г

Ан ав зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.1.1, 21.1.2, 21.1.3 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1, 28.2, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын нутаг дэвсгэрт саарал чонын тоо толгой нь ихсэж мал сүрэгт нөлөөлж малчдаас санал хүсэлт ирж байгаатай холбогдуулан "Хангай" агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ан ав зохион байгуулсугай.

2. Ахуйн зориулалтаар агнуур зохион байгуулалт хийх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Галт зэвсгийн эзэмшил, бүртгэлтэй эсэх зөвшөөрөгдсөн зэвсэг хэрэгсэл, техникийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасаг (Б.Алтангадас), Мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чонын ан ав зохион байгуулах үйл ажиллагаанд багийн иргэдэд мэдээ мэдээллийг хүргэн идэвхтэй оролцохыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтын дагуу ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнахад, эрхийн бичиг олгож, экологи эдийн засгийн үнэлгээний төлбөрөөс чөлөөлж, гарал үүслийн тодорхойлолт хийж, бусад амьтныг айлгаж, үргээхгүй байхад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ж.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

D:\2024\on\Zan\am\2024\on-docx 642401377

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

